

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

Шийдвэр ийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ					
1	1	<u>2023.12.27</u> <u>№471</u> <u>Жагсаалт, журам</u> <u>батлах тухай</u>	Засгийн газрын 2023 оны “Жагсаалт, журам батлах тухай” 471 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 1.5 хувиар төлөх ажил мэргэжлийн жагсаалт”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 2.5 хувиар төлөх ажил мэргэжлийн жагсаалт”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам”-ыг 2024.02.22-ны өдрийн 04/360 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.	100	
2	1	<u>2023.12.27</u> <u>№469</u> <u>Дүрэм батлах</u> <u>тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.15 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрмийг Засгийн газар батална” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Дүрэм батлах тухай” 469 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”, “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм”-ийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.		
3	1	<u>2024.01.03</u> <u>№02</u> <u>Худалдан авах</u> <u>ажиллагаанд</u> <u>баримтлах төсөвт</u> <u>өртгийн дээд</u> <u>хязгаар тогтоох</u> <u>тухай</u>	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр зохион байгуулагдах нийт 145.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авалт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 40.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 худалдан авалтын төлөвлөгөөг батлан, ажлыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгуулж, шалгарууллаа. Үүнд: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 1 худалдан авалт: ✓ Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай маягт бэлтгэх 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 09 дүгээр сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулж, нэг оролцогч “Адмон принт” ХХК-тай гэрээ байгуулан маягтуудыг хүлээн авч, гэрээний дагуу 39.95 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2. Нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр батлагдсан 2 худалдан авалт: ✓ Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн гарын авлага, тараах материал хэвлэх, эх бэлтгэх 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 14-ний өдрийн хооронд зохион байгуулж, шалгарсан “Адмон принт” ХХК-тай гэрээ		

			байгуулан тараах материал хүлээн авч, гэрээний дагуу 58.96 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Ажил олгогч, даатгуулагчдад зөвлөн туслах үйлчилгээний лавлах утас, цахим хариу үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах 65.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар 2024 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны хооронд зохион байгуулж 57.91 сая төгрөгийн хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Колл Про” ХХК-тай ажлын гэрээ байгуулсан.		
4	1	<u>2024.01.10</u> <u>№10</u> <u>Итгэлцүүр тогтоох</u> <u>тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө” гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Итгэлцүүр тогтоох тухай” 10 дугаар тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Шийдвэр хүргүүлэх тухай” 04/243 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.		
5	1	<u>2024.01.10</u> <u>№14</u> <u>Монголбанкны</u> <u>үнэт цаас</u> <u>худалдан авах</u> <u>хөрөнгийн</u> <u>хэмжээг батлах</u> <u>тухай</u>	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 14 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад 2024 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаас худалдах, худалдан авах 199/НД73/24 дугаартай гэрээг Сангийн яамтай байгуулж, эхний 100,000.0 сая төгрөгийг 8.5 хувийн хүүтэйгээр 1 жил, хоёр дахь 100,000.0 сая төгрөгийг 9.0 хувийн хүүтэйгээр 2 жил, гурав дахь 100,000.0 сая төгрөгийг 9.5 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатайгаар тус тус худалдан авч, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүллээ. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг санхүүгийн найдвартай хэрэгсэлд оруулснаар сангийн хөрөнгийг 55.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэн зорилтот түвшинг бүрэн хангасан.		
6	7,8	<u>2024.02.28</u> <u>№84</u> <u>Тогтоолд хавсралт</u> <u>нэмэх, тогтоолын</u> <u>хавсралт өөрчлөн</u> <u>батлах тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/53 дугаар тушаалын хавсралтаар Төсвийн байгууллагын үйлчилгээний ажилтан-1, Угтах үйлчилгээний ажилтан-1 орон тоотой баталсан бөгөөд 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн уг тогтоолын дагуу Төсвийн байгууллагын үйлчилгээний ажилтныг ТҮ-6, Угтах үйлчилгээний ажилтныг ТҮ-5 болгон албан тушаалын зэрэглэлийг өөрчилсөн.	100	
7	1	<u>2024.03.20</u> <u>№120</u> <u>Тэтгэврийн</u> <u>хэмжээг</u> <u>нэмэгдүүлэх тухай</u>	Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 540.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 500.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж, дундаж тэтгэвэр 785.6 мянган төгрөг болов.		

8	1	<u>2024.12.18</u> <u>№221</u> <u>Тэтгэврийн</u> <u>хэмжээг</u> <u>нэмэгдүүлэх,</u> <u>тэтгэврийн доод</u> <u>хэмжээг шинэчлэн</u> <u>тогтоох тухай</u>	Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6.0 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж, дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөг болов.		
9	3 дугаар хавсралт	<u>2024.03.27</u> <u>№128</u> <u>Төрийн албаны</u> <u>зарим албан</u> <u>тушаалын</u> <u>цалингийн хэмжээ,</u> <u>доод хэмжээг</u> <u>шинэчлэн тогтоох</u> <u>тухай</u>	Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”-ыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг шинэчлэн батлах тухай” А/57 дугаар тушаалаар албан хаагчдын үндсэн цалинг шинэчилсэн.	100	
10	1	<u>2024.12.25</u> <u>№231</u> <u>Итгэлцүүр батлах</u> <u>тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө” гэж заасны дагуу Засгийн газрын газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Итгэлцүүр батлах тухай” 231 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Бодлогын даалгавар хүргүүлэх тухай” 01/2769 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төвд тэтгэврийн программд өөрчлөлт оруулах бодлогын даалгавар хүргүүлэв. Уг бодлогын даалгаврын дагуу Мэдээллийн технологийн төв тэтгэврийн программд өөрчлөлт оруулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгохоор сонгосон цалин, хөлсийг итгэлцүүрээр өсгөн тогтоолгох нөхцөлийг бүрдүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.		
11	1,2,3,4,5, 6,7	<u>2024.04.03</u> <u>№138</u> <u>Хууль</u> <u>хэрэгжүүлэх</u> <u>талаар авах зарим</u> <u>арга хэмжээний</u> <u>талаар</u>	Засгийн газрын 2024 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19, А/74 дүгээр тушаалуудыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/51 дүгээр тушаалаар аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/52 дугаар тушаалаар дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог, 2024 оны “Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” А/53 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог тус тус шинэчлэн баталсан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүтэц,	100	

			орон тоо, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/44 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Засгийн газрын 2024 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоолоор Нийслэлийн нийгмийн даатгалын газрыг татан буулгахаар шийдвэрлэсэн. Энэ шийдвэрийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нийслэлийн нийгмийн даатгалын газрын талаар авах арга хэмжээний тухай” А/50 дугаар тушаал гарган холбогдох зохион байгуулалтыг хийсэн бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Албан хаагчдыг шилжүүлэх тухай” Б/28 дугаар тушаалаар Нийслэлийн нийгмийн даатгалын албан хаагчдыг Нийгмийн даатгалын ерөнхий газар болон дүүргүүдийн Нийгмийн даатгалын газруудад шилжүүлэн ажиллуулсан.		
12	1	<u>2024.06.06</u> <u>№254</u> <u>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам батлах тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл болон Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам” -д нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж, Арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламж зэрэг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно гэж заасан. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах доод хэмжээг 300.0 тэрбум төгрөгөөр, мөн Засгийн газрын 2024 оны “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” 14 дүгээр тогтоолоор сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад 2024 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 300.0 тэрбум төгрөгөөр тогтоосон. Тус газраас 2024 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Сангийн сайдад Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 2024 онд 300.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын бонд худалдаж авах талаар хүсэлт хүргүүлж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн тул сангийн чөлөөт үлдэгдлээс 300.0 тэрбум төгрөгийн 3 жилийн хугацаатай, дунджаар 9 хувийн хүүтэй Засгийн газрын бондыг Сангийн яамтай гэрээ байгуулан худалдан авч, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын 254 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажилласан. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг санхүүгийн найдвартай хэрэгсэлд хөрөнгө оруулснаар сангийн хөрөнгийг 55.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.	100	
13	1	<u>2024.06.06</u> <u>№256</u>	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор	100	

		<u>Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам батлах тухай</u>	даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар зохицуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тэтгэврийн нөөц санд хөрөнгө, төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, хяналт тавих журам”-ыг Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан. Хууль, журамд тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан. Үүнд: 1. Албан журмын болон сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн 2 хувийн орлого, 2. Ирээдүй өв сангийн хөрөнгө оруулалтын цэвэр өгөөжөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлогоос Засгийн газрын тогтоосон хэмжээгээр (эрдэс баялгийн орлогоос бүрдүүлсэн тус сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг 2030 оноос улсын төсөвт төвлөрүүлнэ), 3. Улсын төсвөөс олгох бусад орлого. Тэтгэврийн нөөц санд 2024 онд улсын төсвөөс хөрөнгө хуваарилаагүй ба 2 дахь эх үүсвэр болох Ирээдүйн өв сангаас хуваарилах хөрөнгө 2030 оноос хэрэгжих тул энэ оны хувьд эхний эх үүсвэр буюу тэтгэврийн даатгалын санд төлөгдсөн шимтгэлийн орлогын 2 хувийг байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/05 дугаар тушаалаар тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, байршуулах, даатгуулагчдад мэдээлэх программын даалгавар боловсруулах ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг баталсан. Уг ажлын хүрээнд программын даалгаврыг боловсруулан НДЕГ-ын 2024 оны 01/641 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн. 2024 онд 973980 даатгуулагчийн 212.3 тэрбум төгрөгийг арилжааны 4 банкны (ХААН, Голомт, ХХБ, Төрийн банк) тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд байршуулж, тэтгэврийн нөөц сангийн хөрөнгө 3 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор өссөн. Даатгуулагчдад ndaatgal.mn аппликейшн болон E-mongolia системээр “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал” цэс үүсгэн мэдээлэл өгч байна.		
14	1	<u>2024.09.25 №96 Жагсаалт шинэчлэн батлах тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу мэдээллийг байршуулж байгаа эсэхэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Тус хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэмжээнд 93.4 хувийн гүйцэтгэлтэй, мөн мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-ээр дүгнэхэд дундаж 92.8 хувьтай үнэлэгдэж тодорхой үр дүнд хүрсэн байна.	100	

			Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд нээлттэй мэдээлэл байршуулахтай холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 02/259 дугаар зөвлөмжийг хүргүүлж ажиллав. Нийгмийн даатгалын байгууллага Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/137 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын статистик мэдээллийн маягтын дагуу жилийн эцсийн болон эхний хагас жилийн статистик мэдээллийг гарган Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн, нээлттэй өгөгдөл цэсэд байршуулан ажиллаж байсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж байгаатай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны А/175 дугаар тушаалаар нийгмийн даатгалын статистик мэдээллийн албан ёсны маягтыг шинэчилж, жилийн эцсийн байдлаар Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр баталсан. Уг батлагдсан маягтын дагуу тоон мэдээллийг нээлттэй өгөгдөлд байршуулан ажиллаж байна.		
15	1	<u>2024.10.02</u> <u>№109</u> <u>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ батлах тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/99 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан. Уг журамд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг бэхжүүлэх, үүднээс дараах заалтуудыг тусгаж мөрдөж байна. Үүнд: • Ерөнхий газрын дэргэд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгаж, дүгнэлт гаргах эрх бүхий Ёс зүйн дэд хороо ажиллана. Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг баримтлан ажиллана; • Ажилтныг Хөдөлмөрийн дотоод журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг шаардах, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх, байгууллагын дотоод дэг журмыг сахиулах, сахилгын шийтгэл ногдуулах буюу эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх; • Ерөнхий газрын албан хаагч гэдгээ бахархан дээдэлж, байгууллагын үнэт зүйл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, өргөсөн тангараг болон хууль тогтоомжийн дагуу албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд шударгаар шуурхай гүйцэтгэж, албан үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, энэхүү журмыг мөрдөж ажиллах; • Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөн бусад ажилтны үйлдэл, эс үйлдэхгүйг илрүүлсэн буюу мэдсэн бол нэн даруй холбогдох ажилтанд мэдэгдэх, зөрчлийг таслан зогсоох талаар зүй ёсны шаардлага тавих; • Мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган албан үүргээ тогтмол чанартай биелүүлж, ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг	100	

			сахиж, байгууллагын болон албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэшлээ байнга дээшлүүлэн ажиллаж, эерэг уур амьсгалыг бүрдүүлж байгаа албан хаагчид дараах шагнал, урамшуулал олгоно; Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан төрийн албан хаагчид Ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр сахилгын шийтгэл ногдуулна; Засгийн газрын 2024 оны “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 03/2139 дугаар албан бичгээр хүргүүлэв. Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн дэд хороодод үүрэг болгон ажиллалаа.		
Хэсгийн дундаж хувь				100	
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ					
16	1	<u>2023.12.04</u> <u>№08</u> <u>Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай</u>	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дах заалтын дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 2 000 000 төгрөгөөр, амьгүй донор холж эд, эс эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3 500 000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2022 оны 04 дүгээр тогтоолыг хүчингүй болгосн байна. Тогтоол шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх зөвлөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 10 -ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай ”01/82 тоот албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Шийдвэр хүргүүлэх тухай” албан бичгээр 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08 тоот тогтоолыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлэв.		
17	1	<u>2023.12.04</u> <u>№09</u> <u>Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай</u>	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалтад заасны дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээ ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгал (тэтгэврийн даатгал)-д албан журмаар даатгуулах шимтгэлийн хэмжээг сарын 50000 воноор тогтоосон НДҮЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай” 09 дүгээр тогтоолыг 2024.02.07-ны өдрийн 04/297 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.		
18	1	<u>2023.12.04</u> <u>№10</u> <u>Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн</u>	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэгт “Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно” гэж заасны дагуу сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох		

		<u>осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай</u>	хэмжээг нэг ор хоногт 70000 төгрөгөөр тогтоосон НДҮЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024.02.07-ны өдрийн 04/297 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.		
19	1	<u>2023.12.04 №12</u> <u>Тогтоол хүчингүй болгох тухай</u>	Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбоотой НДҮЗ-ийн 2023 оны 12 тоот “Тогтоол хүчингүй болгох тухай” тогтоолоор 2021 оны 09 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг хүчингүй болгосон байна. Уг тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Шийдвэр хүргүүлэх тухай” 04/297 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.		
20	1	<u>2023.12.21 №15</u> <u>Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг батлах тухай</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны “Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг батлах” тухай 15 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд даатгуулагчдын нэрийн дансны 2022 оны эцсийн үлдэгдэл, 2023 онд төлсөн шимтгэлийн орлогод хүү тооцон, 2023 оны жилийн эцсийн нэрийн дансны нийт үлдэгдлийн дүнг гаргаж, “Нийгмийн даатгал” аппликэйшн, www.ndaatgal.mn цахим хуудсан дахь “Даатгуулагчид зориулсан вэб”, төрийн байгууллагуудын мэдээлэл солилцооны “ХУР” систем, төрийн үйлчилгээний нэгдсэн портал “E-Mongolia” систем, ТҮЦ машин зэргээс харах, татах, хэвлэж авах боломжийг бүрдүүлэв. Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2023 оны орлогод 1.627.3 мянган даатгуулагчийн 33.2 их наяд төгрөгийн шимтгэл болон шимтгэлд тооцсон хүүг бүртгэв.		
21	1	<u>2023.12.21 №20</u> <u>Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай</u>	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Үндэсний статистикийн хороо, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр тогтооно” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход браимтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл “к” коэффициентийг 2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жил байхаар тогтоосон НДҮЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай” 20 дугаар тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024.02.07-ны өдрийн “Шийдвэр хүргүүлэх тухай” 04/297 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.		
22	1	<u>2023.12.21 №22</u> <u>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд</u>	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлэгдлээс 2023, 2024 онуудад арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулаагүй.		

		<u>байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг тогтоох тухай</u>			
23	1	<u>2024.03.05 №01</u> <u>Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам батлах тухай</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024.03.05-ны 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ыг хууль зүйн яам бүртгэж аваагүй тул 2025 онд шинэчлэн боловсруулж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ыг шинээр батлуулж хууль зүйн яаманд бүртгүүлэв. Уг журмын дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн нийт 1626.8 мянган даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд 2023 онд 14.3 хувийн хүү тооцон 33141.8 тэрбум орлогыг бүртгэн, иргэд даатгуулагчдад мэдээлэн ажиллав.		
24	1	<u>2024.06.10 №02</u> <u>Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих журам батлах тухай</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/218 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтыг 2024 оны 12 дугаар сард зохион байгуулав. Сонгон шалгаруулалтын урилгыг “Зууны мэдээ”, “Өнөөдөр” сонин болон олон нийтийн сүлжээнд байршуулсан ба нийт 5 оролцогч хүсэлт ирүүлсэн болно. Ажлын хэсгийн хурлаар Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төв болон сувиллын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн сэргээн засах үйлчилгээ, оношилгоо, эмчилгээг сайжруулах чиглэлээр тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байдалд үнэлгээ хийж, нийслэлийн Багануур дүүргийн “Багануур сувилал ХК”, Хан Уул дүүргийн “Оргил рашаан сувилал ХК”, Орхон аймгийн “Эрдэнэт сувилал”, Дархан Уул аймгийн Шарын гол сумын “Тулга сувилал”-тай “Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан ажиллаж байна.		
25	1 дүгээр хавсралт, 2 дугаар хавсралт	<u>2024.06.10 №06</u> <u>Ажил олгогчид ажилгүйдлийн</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ажил олгогчид ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журам”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлт үзүүлэх, хяналт тавих журам”-ыг тус тус Нийгмийн		

		<u>даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журам батлах тухай</u> <u>Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлт үзүүлэх, хяналт тавих журам батлах тухай</u>	даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/2058 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэв. Мөн тус албан бичгээр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.2-т заасан нөхцөлийг хангасан ажил олгогчдод хүргүүлсэн журмуудын дагуу шимтгэлийн хөнгөлөлтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үзүүлэх чиглэлийг хүргүүлж ажиллалаа. Харин Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан шимтгэлийн чөлөөлөлтийг ажил олгогчид үзүүлэх холбогдох журмыг боловсруулахаар ажиллаж байна.		
26	1	<u>2024.09.06 №07</u> <u>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам батлах тухай</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч, эздийн нэгдсэн холбоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв зэрэг холбогдох байгууллагуудын саналыг тусган “Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө”-г 4 чиглэлээр нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр тогтоолоор батлуулсан. Журмын 2.1 дэх хэсэгт заасны дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулах ажиллагааг тайлант онд багтаан зохион байгуулах боломжгүй болсон бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 26 арга хэмжээнээс 2 арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллав.		
27	1	<u>2024.11.08 №08</u> <u>Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай</u>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024.11.08-ны өдрийн "Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай" 08 дугаар тогтоолын дагуу нийгмийн даатгалын сангийн өр төлбөрт тооцон шилжүүлэн авах 5.07 тэрбум төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авахтай холбоотойгоор хийгдсэн ажлууд:		

		✓ Чингис хаан банк болон ШШГЕГазрын Банкны төлбөр барагдуулах газарт 2024.11.15-ны өдрийн "Мэдэгдэл хүргүүлэх тухай" 01/2382 дугаар албан бичгээр "Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай" 08 дугаар тогтоолыг хүргүүлсэн. ✓ Уг тогтоолыг хүргүүлснээр ШШГЕГазрын Банкны төлбөр барагдуулах газраас 2024.11.25-ны өдрийн "Өмчлөх эрх шилжүүлэх тухай" 1/5834, 1/5835 дугаар албан бичгүүдээр Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд өр төлбөрт тооцон шилжүүлэх хөрөнгүүдийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт шилжүүлэх шийдвэрийг холбогдох баримтын хамт хүргүүлсэнМөн Чингис хаан банк ХХК-иас Хан-Уул дүүрэг, 4-р хороо, Нүхтийн ам, Нүхтийн зам гудамж, 24/3, 24/4 тоот хаягт байрлах амины орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгүүдийн Ү-2206065792, Ү-2206065793 өмчлөх эрхийн гэрчилгээг эх хувиар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, 17-р байр, 13 давхарт байрлах оффисын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн Ү-2203029766 өмчлөх эрхийн гэрчилгээний хуулбарыг 2024.12.17-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. ✓ Эдгээр хөрөнгүүдийн гэрчилгээг хүлээн авснаар тус газар нь 2024.12.18-ны өдрийн "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/2623, 01/2624 дүгээр албан бичгүүдээр өр төлбөрт тооцон хүлээн авах хөрөнгүүдийн өмчлөх эрхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /9081739/-ын нэр дээр шилжүүлэх мэдүүлгийг Хан-Уул, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст гаргасан. ✓ Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тус газраас хүргүүлсэн мэдүүлгийг шалгахад хугацаа алдсан, мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас дээрх хөрөнгүүдтэй холбоотой дуудлага худалдааны тогтоолыг ирүүлээгүй материал дутуу гэх шалтгаанаар шийдвэрлээгүй хүлээгдэж байна. Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, 17-р байр, 13 давхарт байрлах оффисын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн холбогдох материалыг ШШГЕГ-аас ирүүлэхдээ уг хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан өмнөх хугацааны шийдвэрийг хүчингүй болгоогүй байна гэх шалтгаанаар хүлээгдэж байна.		
Хэсгийн дундаж хувь			100	
НИЙТ ХУВЬ			100	